

Орхон бүсний пролетариат нар нэгдэвчтүн!

АНХ ДЭГДЭЭР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ

№ 79 (2353)

1974 оны 10 дугаар сарын 21

ДАВАА

НЭМЭЛТ ҮҮРЭГ АМЛАЛТ АВЧ БАЙНА

Борнуурын САА-н төв, хөдөөд хөдөлмөрчдийн цуглаан болж манай хүндэт зочин ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л. Н. Брежневийг хөдөлмөрийн өндөр амжилтаар угтахад илэрхийлж үүрэг амлалт авч байна.

Өнгөрсөн 7 хоногт Борнуурын САА-н мал аж ахуйн 9 бригад 35 суурьт ийм цуглаан болж шинэ амжилтын төлөө уралдаж ажиллахаа илэрхийлжээ.

Саалийн Л. Саидан даргатай 111 бригадын саалыг 250 мянган литр сүү бэлтгэх үүргээс дутуу байгаа 29865 литр сүүг Л.Н. Брежнев даргын цэрхийн өмнө биелүүлэхийн дээр өвлийн бэлтгэл ажлаа бүрэн хангах үүрэг авчээ.

Р. БЯМБАРИНЧИН

ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ КОМИСС

МАХН-ын Төв Хорооны удирдаж, заалтын дагуу аймгийн Намын анхан шатны байгууллагуудад захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих комиссууд байгуулагдан ажиллаж эхэллээ.

Намын анхан шатны байгууллагын ажиллаж байгаа ноцлоос үндэслэн комиссын эрхлэх гол үүрэг, ажиллах хугацааг хариуцаан ашиггүй байж болно.

Гэхдээ комиссууд захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг хэрэгжүүлэхдээ юуны өмнө улсын төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр нь биелүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж оорийн өртгийг хямдруулах, шинэжлэх ухааны үндэстэй хөдөлмөр зохион байгуулалт нэвтрүүлэх, эд материалын болон санаа сэтгэлийн урамшилгыг хослох, боловсон хүчнийг сонгон авах, хуваарилах, хүмүүжүүлэх, мэдлэг нэр-гэжлийг дээшлүүлэх, аж ахуйг хөгжлөх арга барилыг дээшлүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй.

Тус аймгийн Намын анхан шатны байгууллагууд одоо гол төлөв өвөлжилтийн бэлтгэлийг хангах, мал сүргийг онд мэнд оруулах, нэг настай малын арчилгааг малаагааг сайжруулах ажилд хяналт тавих комиссуудыг түр хугацаагаар байгуулан ажиллуулах байна.

Захиргааны үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх комисс Намын дүрмээр олгогдсон эрхээ биелүүлэхэд нь анхан шатны байгууллагууд идэвхтэй туслаж, түүний өдөр тутмын удирдлагын дор үйл ажиллагааг явуулах ёстой.

Комиссын ажлын гол агуулга нь дутагдлын баримтуудыг бүртгэхэд бич, харин түүнээс урьдчилан сэргийлж дутагдлыг цаг алдалгүй засах, ажил хэргийг сайжруулах, шалгалт гүйцэтгэл хоёрыг нэгдэл болгоход оршидог.

Захиргааны үйл ажиллагаанд тавих Намын хяналт нь шалган байцаагчийн байдлаар бич, харин хамт олныг зохион байгуулагч, сурган хүмүүжүүлэгчийн ёсоор явагдах ёстой.

Үүний хамт төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх талаар санаа тавьдаггүй, залуу хойрго байдал гаргадаг, хуурч мэхэлдэг, нам, засгийн тогтоол удирдамжийг биелүүлэхэд хайхрамж муутай ханддаг ажилтныг зарчимч ёсоор шүүмжлэх хэрэгтэй.

Шаардлагатай үед комисс нь байгууллага, газрын ажлын байдлыг бүхэлд нь буюу нэгж хэсгийн нь хэмжээгээр авч үзэж уг ажлын байдлыг мэдэгдэн сайжруулах замаар хяналтын эрхээ хэрэгжүүлэх ёстой. Комиссын ажлын үр нөлөөг сайн байлгахын нэг чухал ноцол нь түүний ажилд захиргааны удирдагчид бүх аргаар туслаж, тэдний шаардсан материалыг цаг тухайд нь гарган өгөх, ажлынхаа талаар үнэн зөв мэдээлэх, комиссын тавьсан санааг шаардлагыг анхааралтай авч үзэж, дутагдлыг цаг алдалгүй арилгах явдал мөн.

Энэ учраас Намын байгууллага, ажилтан уг асуудалд хэрхэн хандаж ямар арга хэмжээ авсан, түүний үр дүн юу болосныг тухай бүрт нь хариу мэдэгдэж байх журмыг хэлбэрэлтгүй биелүүлж байвал зохино.

Намын байгууллага зөвхөн орооо захиргааны үйл ажиллагааг хянаад зогсохгүй, дороос тавих бүх хяналтыг чиглүүлж ардын хяналтын болон, хяналтын бүх төрлийн байгууллагын хамтын ажиллагааг орнуулан ажиллах явдал Намын анхан шатны байгууллагын ажил амжилттай байхын нэг чухал үндэс мөн.

Хэвлэл захиалалт

Угтаалын САА-н дунд гийн байдлаар 31 төрсургуулийн багш сурагчдийн дунд ЗХУ-ын шинэ оны хэвлэл захиалах ажил өрнөлттэй явагдаж одоо-

Сурагч СУНДУЙ

Аймгийн Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны ТОГТООЛ ЧУУЛГАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

1974 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 113

Зуунмод хот

Аймгийн Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргаанаас Т О Г Т ООХ НБ:

1. Аймгийн Ардын Депутатуудын Хурлын 10 дахь удаагийн сонгуулийн 6 дугаар чуулганыг 1974 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Зуунмод хотод хуралдуулсугай.

2. Чуулганд бод малын тогтвортой

өсөлтийг хангах зарим арга хэмжээний тухай асуудал хэлэлцүүлсүгэй.

3. Аймгийн чуулганыг угтсан өндөр бүтээлийн сарын ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллахыг сум, хот, хороодын Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргаад, үйлдвэр аж ахуйн газрын дарга нарт даалгасугай.

Аймгийн Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга Ч. ДАШДЭМБЭРЭЛ
Аймгийн Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны хариуцаагатай нарийн бичгийн дарга Г. ШАРАВ

Курганыг сурталчлах долоо хоногийн нээлт

Монгол-Зөвлөлтийн уламжлалт найрамдлын 23 дахь сарын ажлын үеэр тус аймагт зохиогдох Курган мужийг сурталчлах долоо хоногийн нээлтийн ажилд зориулсан Зуунмод хотын нам, улс, олон нийтийн байгууллага, хөдөлмөрчдийн төлөөлөгчдийн - баярын цуглаан энэ сарын 18-нд аймгийн Соёлын ордонд боллоо.

Цуглаанд аймгийн Намын хорооны товчоо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны зарим гишүүд, МЗНН-ийн аймгийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүдээс гадна тус аймагт зочилж байгаа Курган мужийн Намын хорооны ахлах лектор В.А. Сорокин, зохиолч, сэтгүүлд В.Ф. Потанин нар оролцлоо.

Баярын цуглааны ажиллагааг аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны хариуцаагатай нарийн бичгийн дарга, МЗНН-ийн аймгийн зөвлөлийн орлогч дарга Г. Шарав нээсний дараа аймгийн Барилга усралтын конторын барилгачин, V таван жилийн гавшгайч Г. Бор, Хүнсний й үйлдвэрийн эдийн засагч Б. Цэвээндүмал нар манай аймагт зочилж байгаа Курган мужийн төлөөлөгчдөөр дамжуулан аймгийнхаа 60 мянган хөдөлмөрчдийн халуун мэндчилгээг дэвшүүлж, Курганы хөдөлмөрчдийн коммунист байгуулалтад их амжилт хүсэн ерөөгөөд найрамдалт Курганчуудын баялаг туршлагаас цуцалтгүй сурагдаж социалист урлаг дааны тугийн дор ажил-

лаж их амжилт гаргахаа илэрхийллээ. Баярын цуглаан дээр аймгийн Намын хорооны нарийн бичгийн дарга, МЗНН-ийн аймгийн зөвлөлийн дарга Х. Билгээ хэлсэн үгэндээ: ЗСБНХОУ-ын Курган муж манай аймаг хоёрын хооронд ажил төрлийн байнгын холбоо тогтоод жил гаруй хугацаа өнгөрөхөд олон сайхан ажлууд зохиогдсоныг дурьдаад долоо хоногийн ажлаар Курганы хөдөлмөрчдийн коммунист байгуулалтын ололт амжилтыг сурталчлахын зэрэгцээ аймгийн аж ахуй соёлын бүх салбарт анд нөхдийнхөө баялаг туршлагаас нь улам шамдан сурталчлаа ажлууд зохиогдох болно гэж тэмдэглэлээ.

Мөн цуглаан дээр тус аймагт зочилж байгаа Курган мужийн Намын хорооны ахлах лектор, эрдэмтэн В.А. Сорокин манай аймагт айлчилсан тухайгаа «Танай орны хэсэгхэн газраар явахдаа тэр олон алдартнууд, хөдөлмөрийн шуутнуудтай уулзаад хийсэн бүтээсний нь нүдээр үзэж танай улс МАХН-ынхаа удирдлагын дор хичнээн их амжилт олсныг ойлгож мэдлээ. Биднийг халуун дотно хүлээн авч байсан баярт үйл явдлыг хэзээ ч мартаггүй гээд Курган мужийг сурталчлах долоо хоногийн ажлын нээлтэд оролцож байгаадаа туйлын баяртай байгаагаа илэрхийлж бид хамтын нэгэн зорилготой болохоор газар нутаг маань алс хол боловч энэ нь манай найрамдалд

саад болохгүй гэж хэллээ.

Тус цуглаан дээр аймгийн Намын хорооны нарийн бичгийн дарга, МЗНН-ийн аймгийн зөвлөлийн дарга Х. Билгээ Курган зоцлоод дурсгалын зүйл гардуулав. Баярын цуглааны үеэр Курганы хөдөлмөрчдийн коммунизм байгуулалтын ололт амжилтыг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэн аймгийн Соёлын ордонд нээгдлээ. ЗСБНХОУ-ын Курган мужийг сурталчлах долоо хоногийн ажлаар «Өнөөгийн Курган мужийн зорилтуудын тухай» бүх байгууллагуудад хөдөлмөрчдийн гэжээрийн хурал болж гэрэл зургийн самбар булан байгуулж сурталчлахын дээр зарим байгууллагууд, Курган мужийн байгууллагуудтай ажил төрлийн шууд харилцаа тогтоох юм.

Мөн Зөвлөлтийн мэргэжилтнүүд ажиллаж буй газар найрамдлын цуглаанууд болж, Курганы нэрэмжит бригадын өдөр лөгүүд явагдахаас гадна Курган муж тус аймгийн хөдөлмөрчдийн өнөөгийн ололт амжилтын талаар сонинууд хоорондоо нүүр солилцох, Курганы тухай орчуулгын ном уншигчдад хүрэх зэрэг олон ажлууд зохиогдох болно.

Энэ бүхэн бол манай аймаг, Курган муж хоёрын хооронд тогтсон ажил төрлийн байнгын холбоог улам бүр ойртуулах чухал арга хэмжээ болох юм.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ
Ш. ЦЭРЭНДОО

МАХН-ЫН III ИХ ХУРАЛ ХУРАЛДСАНЫ БОЛОН БНМАУ-ЫГ ТУНХАГЛАСНЫ 50 ЖИЛИЙН ОЙД

МАХН-аас эдийн засгийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлсэн нь

Намын III их хурал Ардын хувьсгалын ирээдүйн тухай асуудлыг хэлэлцээд монгол улсыг капиталист бус хөгжлийн замаар хөгжүүлэхийг жанжин шугам болгон баталсан билээ.

МАХН-ын эдийн засгийн бодлогын стратегийн гол асуудал нь феодалын эдийн засгийн үндсийг устгах, худалдаа мөнгө хүүлэх гадаадын капиталыг аажмаар хязгаарлан хавчигч бүрмөсөн шахан зайлуулах замаар гадаадын капиталын хараат байдлаас ангижрах, улс орны үйлдвэрлэх хүчний хөгжлийн нийт өрнөлтийг хангах зорилгоор малчин ардыг хамжлагын эрхшээлээс ангижруулан тэдний эдийн засгийн сонирхол санаачлагыг дэмжин урам шуулж аж ахуйн хувна аргацаасан шинжийг арилган таваарлаг чанарыг дээшлүүлэх, улс хоршооллын аж үйлдвэр болон худалдаа, механикжсан тээвэр, холбоо, үндэсний сан хүү зээлийн системийг байгуулан хөгжүүлж, шинэ үйлдвэрлэлийн харилцаа, үйлдвэрлэх хүчний үндсийг бий болгоход оршиж байв.

Монгол улсыг капиталист биш замаар хөгжүүлэх зорилтыг намын III их хурал намын жанжин шугам болгон тавихын хамт энэ шугамыг хэрэгжүүлэхийн тулд улс, хоршооллын өмчийг өргөтгөн бэхжүүлэх зарим арга хэмжээг төлөвлөн заажээ.

Их хурлын тогтоолд: —Манай улсын дотор бүхий эдийн засагт холбогдох ашиг бүхий зүйлийг аливаа гадаад дотоодын хүмүүст онц өрх болгон олгохгүйгээр гагцхүү улсын сан ба ардын хоршоо ноос явуулж гүйцэтгүүлбэл зүйтэй" гэсэн нь тус орны байгалийн баялгийг ашиглах, үйлдвэрлэлийг

улс хоршооллын мэдэлд байлгах гэсэн зорилт байв. Мөн барааг гадаадад гаргах ба гадаадаас оруулах онц эрхийг харилцан тусалцах хоршоонд олгох нь зүйтэй гэж үзэж хоршоог улам бэхжүүлэн үйл ажиллагаагийн нь идэвхжүүлэхийн тул хошуудад хоршооны салбар байгуулах, аймаг хошуудыг хоршооны гишүүн болгох, улсын татварт хураасан мал, түүхий эдийг цөм хоршоонд худалдаалах журмыг тогтоожээ.

Албан газрууд гадаадын худалдаачдаас мөнгө зээлэн өр тавих явдлыг хориглож банкнаас зээл олгож байхаар заасны гадна албан ба аж ахуйн газруудын мөнгийг банкинд хадгалуулж тэдгээрийн орлого зарлагыг банкнаас эрхлэн гүйцэтгүүлж байлаа.

Намын III их хурал тус оронд соёлыг хөгжүүлэх асуудлыг их анхаарч хүн амыг бичиг үсэгт сургах, бага, дунд сургуулийг олшруулан тэдгээрийг сургах бичгээр хангах, шинжлэх ухааныг хөгжүүлэх, ялангуяа шинжлэх ухааны эмнэлэг нэвтрүүлэх зорилтуудыг тавив.

Хувьсгалын ардчилсан шатанд социалист аж ахуйн хэвшил бүрэлдэж улс ардын аж ахуйн командлах өндөрлөгүүд улсын мэдэлд төвлөрч ардын ардчилсан байгууллагат эдийн засгийн бааз суурь бүрэлдэн тогтсон юм.

Улс ардын аж ахуйн биеэ даасан салбар болсон аж үйлдвэр хөгжлийн зэрэгцээ үндэсний ажилчин анги бий болж өслөө.

Энэ үеийн намын эдийн засгийн бодлогын гол чиглэл үндэс нь социализм байгуулах Лениний төлөвлөгөө байв.

Уг төлөвлөгөө бол үйлд

вэрлэх хүчний хөгжил, нийгмийн харилцааг өөрчлөн байгуулах явдал, хүмүүсийн оюун санааны өөрчлөлт зэрэг нийгмийн амьдралын бүх давхрааг хамарч байв.

Лениний төлөвлөгөөний харилцан уялдан үндсэн гол шижим нь улс орныг үйлдвэржүүлэх ХАА-г социалист ёсоор хоршоолох, соёлын хувьсгал хийх явдал байлаа.

МАХН, энэ зорилтыг хэрэгжүүлэхдээ Лениний хоршооллын төлөвлөгөөг удирдлага болгон хоршооллын хөдөлгөөнийг сайн дурын үндсэн дээр Лениний зарчмыг баримтлан явуулсны үрээр ХАА-г социалист ёсоор өөрчлөн байгуулах ажил 50-иад оны эцсээр бүрэн шийдвэрлэгдэв.

Ардын хувийн аж ахуйтныг хоршоолох ажлыг амжилттай дуусгаснаар эдийн засгийн олон хэвшил арилж, улс ардын аж ахуйн нэгдсэн социалист систем бүрэлдэн тогтов.

Ингэж үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх социалист өмч нийгмийн эдийн засгийн бат бааз бий болж хүн бүр чадлынхаа хирээр хөдөлмөрлөж, хөдөлмөрийнхөө хирээр авах социализмын үндсэн зарчим тогтож нийт улс ардын аж ахуйд социалист үйлдвэрлэлийн харилцаа ялав.

Социализмын материал техникийн баазын үндсийг байгуулах гол зам бол социалист үйлдвэржүүлэлт мөн.

МАХН, тус оронд социализмын үндэс байгуулах үедээ юуны өмнө орон нутгийн дотоодын нөөцийг өргөн ашиглах, хөдөө аж ахуй ялангуяа мал аж ахуйгаас гарч байгаа түүхий эдийн баа

(Тогсгол нь IV нүүрт)

КУРГАНЫ ЗОЧИД ХӨДӨӨ НУТАГТ

Алтанхан намар гэж монгол хүн бахархан нэрлэдэг өгөөж баян намрын нарлаг сайхан өдрүүдэд Зөвлөлт Курган мужийн төлөөлөгчид тус аймагт зочлон ирсэнд Төв аймагчууд нэн баяртай байна. Манай эрхэм зочин, эрдэмтэн В. А. Сорокин, зохиолч-сэтгүүлч В. Ф. Потанин нар Жаргалант, Борнуур, Батсүмбэрийн САА-гаар саяхан зочлов.

Зочид эхлээд ЗХУКН-ын XXII их хурлын нэрэмжит Жаргалантын САА-д айлчилж аж ахуйн дарга, хөдөлмөрийн баатар Д. Аръяа, намын хорооны нарийн бичгийн дарга Н. Дашням, хөдөлмөрийн баатар Д. Төмөрдорж, С. Цагааншүхэрт, Ч. Дугарсүрэн нар болон бусад олон тэргүүний сайчуудтай уулзаж ажил төрөл, амьдрал ахуйтай нь танилцаж хамт олноороо МЗНН-ийн гишүүд болсон энэ САА-гаас хөдөлмөрийн баатар И. Улсын аварга сайчууд 43 төрсний дээр олон хүнтэй рийн дээд шагнал олон медалиар шагнагдсан ажилт бүтээлийг өндөрөө үнэлж, баяр хүртэж улам их амжилт олохыг ерөөв.

Мөн зочид төлөөлөгчид тус САА-н 10 жилийн дунд сургууль дээр очиж В. И. Ленин, Д. Сүхбаатар нарын танхимын ажиллагаатай танилцаж, пионер сурагчидтай хамт зурагаа авахуулж, пионер багачууд аас сурлагын амжилт ерөөж өндөр мэдлэг боловсролтой иргэд болохыг захив. Дараа нь ЗХУ-ын тусламжаар байгуулагдсан тус САА-н үрийн пунктний ажиллагаатай танилцаж, САА-н хоньчин Л. Цэрэнтэй сүргийн бэлчээрт уулзаж түүнтэй элэгсэг дотно ярилцав.

Хоньчин Л. Цэрэн зочид нарийвтар ноост өөхөн сүүлт 750 хонь хариуцан маллаж энэ жил хонь бүрээс 2,7 кг ноос ашиглаж, сүрэг мэнд байгаа

тухайгаа зочдод ярьж улам их амжилт гаргахыг илэрхийлэв.

Манай эрхэм зочид Эрнст Тельманы нэрэмжит Борнуурын САА-д айлчилж, тус САА-н малчин, аймгийн аварга С. Хүрлээ, БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат, нобочин Цэрмаа нартай уулзаж ажил төрөл амьдрал ахуй байдлын нь талаар асууж сонирхсоныхоо дараа мөн САА-н саалийн үнэний фермийн малчин Л. Самдангийнхаар ороход тэднийх зочдоо айраг, цагаан идээгээр дайлав.

Зочид монгол гурт тухлан сууж, айраг цагаан идээгээр зочлуулах зуураа цахилгаан саалтуураар үнээгээ сааж байгаа энэ фермийнхний амжилтыг сайшаав.

Зочид 3 дахь өдрөө Партизаны нэрэмжит Батсүмбэрийн САА-д хүрэлцэн ирж тус САА-н клуб, 8 жилийн дунд сургуулийн ажиллагаатай танилцаж, хөдөлмөрийн баатар А. Авирмэд, Я. Должинжав, Д. Долгор, Улсын аварга ногоочин, илгээлийн эзэн Д. Лайгуй, Л. Хэнзээ нартай уулзаж ярилцав.

Хөдөлмөрийн баатар А. Авирмэд зочдод 31 настайдаа нутгийн монголчид бүрээс 2007 литр сүү сааж, нам засгийн өндөр шагнал-хөдөлмөрийн баатар цол хүртэж, алтан соёмбоор энгэрээ мялаадгаснаа, мөн ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л. И. Брежневт манай оронд 1966 онд зочлох үед хүндэтгэлийн сертификат дээр охин Уртнасан нь эрхэм дээд зочинд мөнгөн аягатай сүү, алд цэнхэр хадаг өргөн барих их хувь тохилдсныг бахархан яриад, одоо саальчдын зөвлөх багшаар ажиллаж олон тэргүүний залуу саальчинд

(Тогсгол нь IV нүүрт)

АРДЫН ХЯНАН ШАЛГАХ ГРУПП ПОСТЫН ТАЙЛАН СОНГУУЛЬ

Ардын хянан шалгах групп постын ээлжит тайлан сонгууль энэ оны 11 дүгээр сард болно.

Ардын хянан шалгах групп постын тайлан сонгууль, өнгөрсөн 2 жилд улс ардын аж ахуй, соёлын салбарт зохион явуулсан үзлэг шалгалт, түүний үр дүн, хяналт шалгалтын арга барил, хуримтлуулсан туршлагыг нэгтгэн дүгнэж АХШБ-ын үүрэг рөлийг өндөржүүлэх талаар намаас тавьж байгаа зорилтыг биелүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болно.

Тайлан сонгуулиа угтаж хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулан

сайжруулах талаар Жаргалант, Угтаал, Борнуур, Бүрэн, Баянцагаан зэрэг сумын АХШ групп, хороод цаг үеийн ээлжит ажлын явцад хяналт шалгалт явуулж түүний үр нөлөөг нь дээшлүүлж байна.

Гэвч АХШ зарим хороо, групп постын ажил тогтмол биш, зохиосон ажлын нөлөө далайц муу байна. Малын зүй бус хорогдлыг багасгах, үйлдвэр, барилгын материал зарцуулалтад хийх үзлэг зарим газар хангалтгүй байна.

Өндөрширээт, Лүн, Баянжаргалант, Заамар зэрэг сумдын малын хорогдол өнгөрсөн оны энэ үеэс болон зүй бус хорогдлыг

багасгах талаар аймгаас тогтоосон хэмжээнээс давжээ. Энэ нь тэндэхийн АХШ хороо, группээс зохиож байгаа хяналт шалгалт эрч далайц, үр дүнгүй байгаагийн илрэл мөн.

Аймгийн төвийн үйлдвэр аж ахуйн газруудын дэргэдэх зарим группийн ажил ор нэрийн төдий байгааг тэмдэглэх хэрэгтэй.

АХШ групп постын тайлан сонгууль угтан, сум нэгдэл, САА, үйлдвэр албан газрын дэргэдэх АХШ хороо, групп түүний харьяа пост бүхэн өөрсдийн ажилд дүгнэлт хийж ажлынхаа дутагдлыг засах, юуны урьд АХШБ-ын өмнө нэр зааж хариуцуулсан

малын зүй бус хорогдлыг багасгах, материал хэмнэх үйл ажиллагааны үр дүнг сайжруулах талаар бодитой ажил зохиох явдал шаардагдаж байна.

Түүнчилэн АХШ байгууллагууд өнгөрсөн 2 жилийн ажлын тайлан илтгэлийг бэлтгэх, шинэ байгууллагдах групп постын байршил, түүний бүрэлдэхүүнийг төлөвлөх, АХШБ-ын үүрэг зорилт, ач холбогдлыг олон түмэнд таниулах зэргээр тайлан сонгуулийн бэлтгэлийг эртнээс хангах нь чухал байна.

АХШГ-ийн тайлан сонгуулийг зөвхөн сумын төвд хийснээр хязгаарлагдах урьдах жилүүдийн дутагдлыг давталгүй аль болох олон түмнийг хамарч тасаг, бригад, цех,

салбар бүрийг хамран явуулбал зохино.

Тайлан сонгуулийн хурлыг ажил хэрэгч санал шүүмжлэлтэй явуулж тухайн групп постын ажилт олон түмнээр үнэлэлт дүгнэлт өгүүлэх нь чухал.

АХШ групп постын тайлан сонгуульд сайн бэлтгэж 1974 оны улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг бүрэн биелүүлэх, мал өвөлжилтийн ажлын сайн зохион байгуулах, малын зүй бус хорогдлыг багасгах, үйлдвэр, барилгын материалыг хэмнэх, социалист өмч төрөнгийг хамгаалах, иргэдээс авах алаалыг хураан барагдуулах зэрэгт хяналт шалгалтын ажлаа идэвхжүүлэн түүний үр нөлөөг өндөржүүлэх нь чухал байна.

Р. ЧИМЭДЦЭРЭН

АХ ДҮҮ КУРГАНЧУУД-БИДНИЙ ДОТНО НӨХӨД

БНМАУ-д манай мужийн хөдөлмөрдний төлөөлөгчид айлчилснаас хойш жил хүрээгүй байгаа ч гэсэн энэхэн ахар богино хугацаанд Төв аймаг, Заураль хоёрын хооронд найрамдал, олон талт холбоо тогтон бэхжлээ. Манайд «Найрамдал» «Дружба» гэсэн монгол үгтэй захидал тогтмол хүлээн авдаг юм.

Түүнд ахан дүүгийн хамтын ажиллагааг улам бэхжүүлэх, хоёр ард түмэн бие биенийгээ улам ойр дотноор мэдэхийг үнэн сэтгэлээсээ хүссэн нь тусгагдсан байдаг.

Энэ хүсэл эрмэлзлэлийг нь хэлбэрэлтгүй ханган биелүүлэхийн тулд мужийн намын байгууллагаас их зүйл хийлээ.

Муждаа Зөвлөлт—Монголын найрамдлын нийгэмлэг байгуулан хөдөөгийн болон завод, сургуулиудын дэргэдэх ан-

хан шатны байгууллагууд үр бүтээлтэй ажиллаж байна.

Тэдгээр байгууллагууд оюутан сэхээтэн, хөдөлмөрдөд, Монголын ард түмний өвөрмөц соёл урлаг, социализм байгуулж байгаа амжилт бүтээлүүдтэй нь танилцуулаа.

Энэ чиглэл дагуу Курганы ХАА-н дээд сургуулийн дэргэд байгуулагдсан Зөвлөлт—Монголын найрамдлын нийгэмлэгийн анхан шатны байгууллагаас олон ажил хийж байгаа юм.

Тус сургуулийн багш оюутнууд, Шмаковийн ХАА-н техник мэргэжлийн сургуульд Монголоос ирж суралцагчидтай уулзалт зохиолоо.

Одоо ойрын хугацаанд тус анхан шатны байгууллагын товчооноос эрхлэн Шмаковийн ХАА-н техник мэргэжлийн сургуулийнханд ярилцлага, лекц

боловсруулан унших ажил зохиохоос гадна Улаанбаатар дахь ХАА-н дээд сургуультай зузаан харилцаа тогтоох гэж байна.

Энэ оны 4 дүгээр сард Курганы нутагт Төв аймгийн хөдөлмөрдний төлөөлөгчид хүрэлцэн ирж зочилсон нь ард түмнүүдийн маань ган бат най-

грамм бүрэн бололцоо олгосон юм.

Төлөөлөгчид эдгээр зүйлүүдийн дотроос нам, ҮЭ-ийн болон ХАА-н удирдлагын талаар маш их сонирхон судалсан юм.

Жишээ нь манай зочид «ЗХУ-ын 50 жилийн ойн нэрэмжит» хамтралд очиж төл хүлээн авах ажлын хөдөлмөр зохион байгуулалттай тодорхой танилцаж улмаар Зауральчуудынхаа туршлагыг өөртөө авч хэрэглэхээр шийдвэрлээ. Мөн Монголоос ирсэн төлөөлөгчид Куртамышскийн районы В.И.Лениний нэрэмжит хамтралд айлчлан тус хамтрал болон, Төв аймгийн Алтанбулаг сумын нэгдлийн хооронд найрамдалт харилцаа тогтоох хэлэлцээр байгуулав.

Энд ажил хөдөлмөрөөрөө өндөр бүтээлийн төлөө уралдах ба туршлагаа солилцоход бие биен-

дээ туслахаар шийдвэрлэсэн юм. Энэ ажил хэрэгч холбоо нь хоёр талыг үрдүнд хүргэх нь зайлшгүй.

Түүнчлэн Монголын ба манай Курган мужийн хооронд соёлын харилцаа байгуулагдсан юм.

Аль хэдий нь найрамдалт оронд «Идэр нас» (молодость) чуулга айлчлаад ирсэн юм.

Цаашид Зауральд—Монголын соёл урлагийн төлөөлөгчид ирэх нь дамжиггүй. Манай ард түмнүүд 50 гаруй жилийн туршид нэгэн жагсаалд мөр зэрэгцэн алхаж байгаа бөгөөд Төв аймаг, Курган мужийн хооронд найрамдалт харилцаа байгуулагдан бэхжиж байгаа нь манай хоёр ард түмнүүдийн найрамдалт хичнээн үнэнч шударга бат бэх болохыг улам тод гэрчиллээ.

«Советская заураль» сонины 1974 оны 160 дугаараас авлаа.

ДРУЖБА

рамдал хэзээ ч эвдэршгүй гэдгийг харууллаа.

Төлөөлөгчдийг хот хөдөөгийн талх, давс, цэцгийн баглаа барин хүндэтгэн зочилж хүлээн авч уулзаж байлаа.

Монгол нөхдөл мужийн ХАА-н ажлын амжилт болон аж үйлдвэрүүд, манай хотууд түүний соёлотой танилцуулж үзүүлэхдээ маань уулзалтын про-

НЭГЭН ЗОРИЛГОТОН

Курган мужийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцож өнгөрсөн намар Монголд очсонодоо барагж явдаг юм.

Ах дүүгийн найрамдалт БНМАУ-ын үндэсний баярын энэ өдөр Монголд байсан өдрүүд эргэн санагдаж байна.

Социалист Монголын малчид, тариачид, аж ахуйн удирдах хүмүүс, намын ажилтнуудтай элэгсэг дотноор уулзан ажил хэрэгчээр ярилцаж байснаа санаж байна.

Чин зүрхнээсээ ах дүүгийн ёсоор харилцан халуун дотно анхаарал санаачилга тавьж байсан явдалаар илэрч байсан интернационал найрамдал маань юунаас илүүтэйгээр сэтгэлд хоногшжээ.

Манай ард түмнүүдийн найрамдал хичнээн бат бэх, үр бүтээлтэй болохыг БНМАУ-ын нийслэл, Төв аймгийн засаг захиргааны төв, мөн аймгийн САА, ХАА-н нэгдэлд очмогцоо бид биеэр үзэж урьдын хоцрогдсон орны нүүр царай яаж өөрчлөгдсөнийг харлаа.

Урьдын нүүдэлчид, одоо суурин амьдралд шилжиж ган хөдлийг итгэлтэй жоолоодог, газар тариаланг чадамгай эзэмшигчид болжээ. САА-н тариалангийн талбайд ажиллаж байгаа Зөвлөлтийн трак-

тор комбайн, автомашиныг манай оронд болон БНМАУ-д сургуулилан техникчид болоодог байна. Зөвлөлтийн мэргэжилтэн нар газар тариалан мал аж ахуйн үйлдвэрлэлийг удирдах, тэргүүний туршлага эзэмшихэд нь ах дүү нартаа туслаж байгаа болон ялангуяа тэдний дунд Курган мужийн элч төлөөлөгч нарыг харахад ч таатайхан байв.

Төв аймгийн төлөөлөгчид, Курганд зочилсон нь хуучин танил анд нөхөдтэй ах дүүгийн ёсоор учран уулзаж бидний сэтгэлийг ихэд хөдөлгөө.

Ах дүү манай орнуудын найрамдал нөхөрлөл бол өргөн хүрээтэй, үр бүтээлтэй байгаа нь Монголд зочилсон өдрүүдэд ч монгол анд нөхөдтэйгөө Курганы нутагт уулзан сая үеэр ахин дахин элэгсэг сэтгэгдлийг төрүүлэв. Ардын хувьсгалын 53 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан хувийн анд нар болон монголын бүх ард түмэнд сайн сайхан, аз жаргал, зорьсон ариун зорилготой хүрэхэд нь улам их амжилт олохыг хүсэн ерөөе.

Бид, коммунист нийгмийг байгуулах нэг зорилготой.

Курган мужийн Атрийн районы «Юный», САА-н дарга Р.КОПЫЛОВА

МАЛЧНЫ СЭТГЭГДЭЛ

Курганчуудын элч төлөөлөгч эрдэмтэн В.А.Со рокин, зохиолч В.Ф.Потанин нартай САА-нхаа төвд халуун дотно уулзан ярилцсанаа би хэзээ ч мартаггүй. Монгол—Зөвлөлтийн ард түмний уламжлалт найрамдлыг манай ард

түмэн нүдний цэцгийг мэт хайрлаж байдаг юм. Курганы хүндэт зочид манай аймагт айлчлан ирсэн нь найрамдал маань улам бүр батжин зузаарч байгаагийн илэрхийлэл юм.

Борнуурын САА-н хоньчин Аймгийн хөдөлмөрийн аварга С. ХҮРЛЭЭ

КУРГАНЫ ТАНЯ, ЛҮНГИЙН ЦЭЦГЭЭ

6-ийн А ангийн М.Цэцгээг онц сурлагатан, дуу хөгжмийн сургуулийн аварга гэдгийг Лүн сумын дунд сургуулийнхан андахгүй.

Саяхан Цэцгээтэй уулзаж амралтаа хэрхэн өнгөрөөснийг сонирхсон юм. Тэрээр би энэ зун маш сайхан амралаа.

Зөвхөн шанз хөгжимд 21 дуу, гитар 19 дуу шинээр тоглож сурсан, бас баянхуур хөгжимд 10 дуу тоглогдож боллоо.

Орос үг 100 гаруйг шинээр чээжилж, Таниядаа захидал бичдэг бол-

сон.Таня бол миний найз.

Манай аймгийн шэф ЗХУ-ын Курган мужийн Петуховскийн районы сургуулийн 8 дугаар ангийн сурагч.Тэр гэртээ 11-үүлээ байдаг, 5 ах, 2 эгчтэй.

Эхээсээ 8-уулаа.

Таня онцсайн суралцаж, хөгжим бүжгийн дугуйланд сурдаг.

Гадаадын марк, ил захидал цуглуулдаг гэж хэзээний анд нөхдийн ёсоор хуурнаа байв.

Энэ хоёр охин өнгөрсөн оны өвлөөс эхлэн захидлаар харилцсан аж.

Танягийнхаа захидлаас

Монгол—Зөвлөлтийн найрамдлын тухай, онц суралцдаг аргын тухай, Зөвлөлтийн хүүхдүүд амралтаа хэрхэн өнгөрөөдөг тухай, гадаадын хэл яаж суралцдаг тухай, их зүйл сурч авснаа Цэцгээ баяр хөөртэй өгүүлэв.

Ийнхүү Курганы Таня, Лүнгийн Цэцгээ хоёр үй зайгүй найзууд болж үргэлж захидал солилцоор байна. Эдийн захидлын мөр бүрт Монгол—Зөвлөлтийн ард түмний найрамдлыг бахархсан сэтгэл шингээстэй байдаг юм.

Л. БАТСУХ

Курган, манай хэвлэлийн хуудсанд

1973 оны 10 дугаар сард Курган муж, манай аймгийн хооронд нөхөрсөг ажил хэрэгч байнгын холбоо тогтоосон тэр үеэс эхлэн ах дүү Курган чуудын амьдрал, коммунизм байгуулалтын үйлсийг сурталчлан нийтлэх ажил «Анхдугаар таван жил» сонины хүндэт байрны эзлэх болсон юм.

Өнгөрсөн хугацаанд Курган мужийн үйлдвэр ХАА-н хөгжилт, манай хоёр орны бат найрамдлын тухай тэргүүн дагавар өгүүлэл, сурвалжлага мэдээ 30 гаруй нийтлэгдсэний гадна Курганчууддаа зориулсан нүүр 3 удаа гаргажээ.

«Зүрхэнд шингэсэн хувьсгалын дөл», «Үлгэрийн хивс», «Курганы хар алт», «Заураль Сибиртэй залгаа нутаг» гэсэн нэр бүхий орчуулгын олон материал нийтлэгджээ.

Сонинд нийтлэгдсэн өгүүлэл сурвалжуудыг манай уншигчид шэф Кур

ганд өрнөж буй социалист уралдаан, аж үйлдвэр, ХАА-н тэргүүний ололт ажлын баялаг туршлагыг ихээхэн сонирхон судалж байна.

Үүнд мал аж ахуйд төрөлжүүлэн хоршоолсон төвлөрсөн нэгдэл байгуулжээ. Энэ ажлыг олоогийн эдийн засгийн тодорхой нөхцөл байдал, түүнд хийсэн сорилт туршилт, тэргүүн туршлагыг үндсэн зохиож үр дүн өгч байна. Курганы САА-нууд өөрийн харьяандаа ажиллаж байгаа сургууль эмнэлэг, ясли, цэцэрлэг зэрэг улсын төсвөөр ажилладаг байгууллагуудыг САА-н зардлаар санхүүжүүлж байгаа болон хөдөлмөрийн тэргүүний сайчуудыг алдаршуулахдаа тэдний том хэмжээний зургийг үйлдвэрийн байр, гудам талбайд амжилтын хамт тавьдаг зэрэг олон шилдэг арга туршлагын тухай уншигчид үзэж болно.

Аймгийн Намын Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц.Адъяа «Нарлаг Курган» өгүүлэл дээ: Нарлаг Курган нутгаар явахад хаана л бол коммунизмын бүтээн байгуулалтын аварга их ажил эрч хүчээ аван, барилга байшин сүндэрлэж шинэ тосгон байгуулагдаж хөдөө нутгийг шинэчлэн өөрчилж байгаа нь нүднээ тусна» гэжээ.

Саяхан «Анхдугаар таван жил» сонины социалист хөдөлмөрийн хэвлэл үйлдвэр Г.Жалбаагийн орчуулсан «Курганы газар зүй» гэсэн сонирхолтой номыг 5000 ширхэг хэвлэн гаргалаа.

Социалист Монголын түүхэн замнал, Төв аймгийн хөдөлмөрдний амьдрал үйл ажиллагааг харуулсан «Наран утгаал» гэсэн нэртэй номыг Курган мужийн Намын Хорооны нарийн бичгийн дарга П.А.Матвеев бичсэнийг монгол хэл дээр орчуулах ажил хийгдэж байна.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

Төгсгөл. (Түрүүч нь
II нүүрт)

зад тулгуурлан ард түмний өргөн хэрэгцээт зүйлсийг үйлдвэрлэх, хөнгөн ба хүнсний аж үйлдвэрийг хөгжүүлж улмаар хүнд үйлдвэрийн салбарыг байгуулав.

Ийнхүү тус орон мал аж ахуйн орон байснаа хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болж хувирав. Нийгмийг хувьсгалт ёсоор өөрчлөхийн салшгүй хэсэг болсон соёлын хувьсгал хийж нийгмийн оюун санааны амьдралыг үндсээр нь шинэчилсэн явдал мөн.

Монголын ард түмэн, МАХН-ын гурван удаагийн программаар дэвшүүлэн тавьсан зорилтыг хэрэгжүүлсний үр дүнд социализм монгол оронд үнэн бодит зүйл боллоо.

Үйлдвэрлэлийн үндсэн хэрэгслийг өмчлөх улс хоршооллын хоёр хэлбэр бүхий нийгмийн соци-

лист өмч нь БНМАУ-ын эдийн засгийн үндэс болов. Монголын ард түмэн капиталист биш замаар хөгжиж колонийн боолчлолоос үндэсний тусгаар тогтнолд, олон зуун жилийн хоцрогдлоос нийгэм эдийн засгийн дэвшилд хүргэсэн түүхэн үсрэлт хийж чадсан нь МАХН-ын эдийн засгийн бодлогын стратегийн ялалт болсон юм.

МАХН-ын III их хурлаас дэвшүүлсэн зорилтын түүхэн ач холбогдол үүнд оршиж байна.

Социализмын үндсийг байгуулсны үр дүнд БНМАУ, жараад оны эхэн үеэс түүхэн хөгжлийн шинэ зурвас үе социализм байгуулж дуусгах үед шилжин оров.

МАХН-ын XV их хурал социализм байгуулж

дуусгах зорилтыг дэвшүүлсэн намын дөрөвдөх шинэ программыг баталлаа. Социализмын материал-техникийн хамгийн ашигтай цогцолбор бүхий бааз байгуулж дуусгах явдал манай нам, ард түмний эдийн засгийн гол зорилт мөн. БНМАУ-ын эдийн засгийн хөгжил улам бүр аж үйлдвэржсэн чиглэлтэй болсоор байна.

50 жилийн ололт амжилтыг өнөөдрийн өндөрлөгөөс эргэн харвал манай ард түмэн, МАХН-ын удирдлагын дор явж эх орондоо социализм байгуулах үйлсдээ сайхан амжилт олж байна.

Улс ардын аж ахуйн үндсэн фонд (1924 оныхыг нэг гэж бодвол) 1973 онд 17 гаруй дахин өсчээ. Урьд манай хөдөө

аж ахуйг 200 гаруй мянган хувийн жижиг аж ахуйтан хоцрогдмол аргаар эрхэлж байсан бол одоо энэ салбарын хувь заяаг хөдөө аж ахуйн 270-аад нэгдэл, 30 гаруй сангийн аж ахуй шийдвэрлэж байна.

1973 онд хамгийн өндөр ургац 500 мянган тонн үр тариа хураан авч энэ онд 9 сая төл бойжуулаад байна.

Аж үйлдвэр 1922 онд үйлдвэрлэж байсан бүтээгдэхүүнтэй тэнцэх бүтээгдэхүүнийг 11 минутад үйлдвэрлэж байна.

Манай улсын 4 хүн тутмын нэг нь ямар нэгсүргүүлд суралцаж байна.

Манайд 10000 хүн тутамд 20 их эмч, больницын 99 ор ноогдож байна. МАХН, тус орны эдийн засгийн хөгжлийн

орчин үеийн онцлогоос үндэслэн улс ардын аж ахуйн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ нийгмийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх бодит бололцоог нягтлан үзэж өнөөгийн шатанд намаас явуулах эдийн засгийн бодлогын үндсэн асуудал намын XVI их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл, их хурлын шийдвэрт тод тусгагдсан юм.

Одоо намын эдийн засгийн бодлогыг шийдвэрлэхэд дотоод нөөц бололцоогоо дүүрэн ашиглаж нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг бүх талаар дээшлүүлэх асуудал чухал байр суурь эзэлж байна.

Энэ зорилтыг хэрэгжүүлсний үр дүнд БНМАУ социалист эдийн засгийн гол гол салбарыг зөв зохистой хосолсон аж үйлдвэр—ХАА-н орон болон хувирах болно.

Б. ЦЭРЭНПҮРЭВ

НЭГДЭЛЧДИЙН ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ

Тус аймгийн нэгдлийн зөвлөлөөс хөдөлмөр хамгааллын комиссыг нэгдэл бүрт байгуулж ажлын ололт дутагдлыг нь тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж заалт өгөх, газар дээр нь шалгаж зааварлаж ажилласнаар нэгдэлчдийн хөдөлмөр хамгаалалд ахиц гарч байна.

Авдархангай нэгдлийн хөдөлмөр хамгааллын комисс хамгаалах хувцас хэрэгслийг бригад, суурь, үйлчилгээний салбарт ажиллагсад бүрээр урьдчилан судалгаа хийсний үндсэн дээр бэлтгэдэг учраас хөдөлмөр хамгааллын хувцас цаг тухайдаа олгогддог байна.

«Саруул-амьдрал», «Энх-туул», «Залуучуудын хөгжил» нэгдлүүд хөдөлмөр хамгааллын дүрэм зааврыг сурталчлан хувцас хамгаалах хэрэгслийн олголтонд шалгалт хийж, малчид ажилчдын эрүүл мэндийн үзлэгийг тогтмолжуулжээ.

«Хайрхан» нэгдлийн хөдөлмөр хамгааллын комисс ажилд шинээр орж байгаа болон илгээлтээр

ирсэн залуу малчдыг аюулгүй ажиллагааны арга барилд сургах, «Энх-туул», «Залуучуудын хөгжил», «Цацрал» нэгдлүүд хөдөлмөр хамгааллын тайланг бригад, хэсгийн хөдөлмөрчдийн хурлаар хэлэлцүүлдэг зэрэг ажлын амжилт гарч, «Сүхбаатарын зам», «Залуучуудын хөгжил», «Цацрал», «Саруул-амьдрал» зэрэг нэгдлүүдэд сүүлийн 3 жил осол гараагүй байна.

Гэвч хөдөлмөр хамгааллын ажлыг нэгдэл бүр жигд сайжруулж чадахгүй, хөдөлмөр хамгааллын хувцас хамгаалах хэрэгслийн хэрэглээнд тавих хяналт сулаас хугацаа болоогүй байхад үрэгдүүлэх, өмсч заншихгүй байх, дутуу олгох явдал байсаар байна.

Ийм байдлаас болж «Шинэ-амьдрал», «Хэрлэн-баян» зэрэг нэгдлүүдэд жил бүр үйлдвэрлэлтэй холбогдсон осол гарчээ.

Хортон нөхцөлд ажиллагсад олгох сүүг таслах, ажлын хорогдуулсан цагтай хүмүүсийг бүтэн цагаар ажиллуулах, илүү

цаг ажиллуулсны хөлсийг олгохгүй байх, эмэгтэйчүүд, 18 насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөр хамгааллыг анхаардаггүй явдал зарим нэгдлүүдэд үзэгдэж хөдөлмөрийн эрхийн тухай хууль тогтоомжийн заалтыг зөрчиж байхад тэдгээрийн дэргэдэх үйлдвэрчний хороо, хөдөлмөр хамгааллын комисс шийдвэртэй арга хэмжээ авахгүй байна.

Иймд хөдөлмөр хамгааллын комиссын ажлыг тогтмолжуулан малчид, ажилчдыг аюулгүй ажиллах арга техникт сурган далагажуулах, нормын сүү, хамгаалах хэрэгслийг хугацаанд нь олгон, хэрэглээнд нь хяналт тавихын зэрэгцээ хөдөлмөр хамгааллын ажилд бүртгэл тооцоо нэвтрүүлэх, гарсан осолын шалтгааныг судлаж дахин гарах замыг хаах, осол гэмтэлгүй нэгдэл хамт олон болох хөдөлгөөнийг өрнүүлж бригад суурийн ажлыг дүгнэхдээ хөдөлмөр хамгааллын ажилтай холбоон дүгнэдэг журам тогтоох нь зүйтэй.

Б. ЦОДОЛ

КУРГАНЫ ЗОЧИД ХӨДӨӨ НУТАГТ

Төгсгөл. (Түрүүч нь II нүүрт)

төрүүлэхээ илэрхийлэв.

Мөн хөдөлмөрийн баатар Д. Долгор, Я. Должинжав нар зочид олон залуу ногоочдыг дагуулан ажиллаж, зөвхөн энэ жил өөрийн шавь улсын аварга ногоочин Д. Лайгүй, Л. Хэнзээ нар гагаас 60—82 тонн байцаа авсан амжилтыг танилцуулав. Зочид тус САА-д байхдаа Д. Сүхбаатарын удирдсан журамт цэрэг хүрээг чөлөөлөх замдаа үдлэж жанжин тугаа босгож байсан Аюушийн аманд очиж түүхт энэ газрыг онцлон сонирхож, дурсгалын зураг авахуулав. Манай эрхэм зочид дээрх САА-нуудаар айлчлах үед олон зуун хүн оролцсон найрамдлын цуглаанууд болж, эрдэмтэн В.А.Сорокин, зохиолч В.Ф.Потанин нар Зөвлөлт Курган мужийн хөгжилт, Зөвлөлт—Монголын найрамдал, хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүй ярьж таниулсан нь хөдөлмөрчдийн талархал хүлээж байв.

Мөн манай эрхэм зочин эрдэмтэн В.А.Сорокин, зохиолч В.Ф.Потанин нарыг Жаргалант, Батсүмбэрийн САА-н 10, 8 жилийн дунд сургуулийн пионерууд хүндэт пионерт элсүүлж, гал улаан бүчээ зүүж өгөн, сайн сайхныг ерөөв.

Зочид дээрхи САА-нуудын нам, улсын байгууллагын удирдах нөхөд тус тусын САА-наа хөгжилт, хэтийн төлөвийг дэлгэрэнгүй танилцуулж зочдын сонирхсон асуултанд тодорхой хариу өгч байлаа.

Зөвлөлт Курганы зочдыг ийнхүү хөдөө нутгаар айлчлахад очсон газар бүрийн хүн ард халуун дотноор хүлээн авч Монгол—Зөвлөлтийн ард түмний элгэн халуун найрамдлын гайхамшигтай сайхан үр дүнг бахархан ярьж, уламжлалт найрамдлаа ямагт хүндэтгэн хайрлаж байдгаа илэрхийлж байв.

Б.ЦЭРЭНДАШ
Д.ДЭМБЭРЭЛДЭШ

Замчид, тээвэрчдийн амжилтаас

МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ой, 1975 онд болох авто тээвэрчдийн 50 жилийн ойг угтсан уралдаан тээврийн байгууллагын хамт олны дунд эрчимтэй өрнөснөөр тээвэрчин хамт олон энэ оны III улирлын ачаа болон хүн эргэлт, зам ба-

рилга засвар, нефть бараа татан авалт, борлуулалтын төлөвлөгөөг 100,5—369,4 хувиар, уралдаанд авсан үүргээ 100,0—363,5 хувиар тус тус биелүүлж жилийн төлөвлөгөөний 75 хувийг гүйцэтгэв.

Замчид тээвэрчдийн дотор V таван жилийн гавшгайч, шууданчин

Ө. Шагдар, замчин Д. Солном, дархан З. Бат-очир, диспетчир Д. Батаа, Ишдаш нарын олон тэргүүний сайчуул хамт олноо уралдаанд хошуучилж явна. Одоо үлдэж байгаа хугацаанд замчид тээвэрчид нэг бүрийн авсан социалист уралдааны амлалтыг бүрэн биелүүлэх, жилийн төлөвлөгөөний дутууг хугацаанаас нь өмнө гүйцээхийн тулд уралдааныг эрчимжүүлэн ажиллаж байна.

С. ОТГОН

ЦАЙ УУХ ЗУУР

—Анх 1921 оны 8 дугаар сард анхны сургууль байгуулж сургуулийн дүрэм баталж, 1924 онд сургуулийг шашнаас тусгаарлан ерөнхий боловсролын сургуулийн сургалтын системийг буй болгож байсан бол одоо тус орны ерөнхий боловсролын 547 сургуульд 274,5 мянган охид, хөвгүүд, тех-

ник мэргэжлийн 26 сургуульд 12 мянган залуус, их, дээд сургуулиудад 7000 гаруй оюутан, хөдөлмөрчдийн ерөнхий боловсролын 360 гаруй сургуульд 18900 хүн тус тус суралцаж, тэдгээрт 14 мянган багш ажиллаж байна. Манай орны 4 хүн тутмын 1 нь ямар нэг сургуульд сурч байна.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ